



ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛ, ҮР ДҮНД СУУРИЛСАН САНХҮҮЖИЛТИЙН ТОГТОЛЦОО ҮР НӨЛӨӨ

АУДИТЫН ХУРААНГУЙ ТАЙЛАН

Аудит хийсэн үндэслэл, бүрэн эрх: Аудитыг Монгол Улсын Их хурлын Төсвийн байнгын хорооны “Аудитын сэдэв батлах тухай” 2022 оны 9 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторовын 2023 оны А/03 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө”-г тус тус үндэслэн Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэгт заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэсэн.

АУДИТЫН ГОЛ ДҮГНЭЛТ: ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН ТОГТОЛЦООНД ШИЛЖСЭН Ч ДААТГУУЛАГЧ ИРГЭН ӨӨРТ ОЙР, ӨӨРИЙН СОНГОСОН ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ДААТГАЛААРАА ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ АВЧ ЧАДАХГҮЙ БАЙНА.

Тайланг хүргүүлсэн этгээд: Дорнод аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, Эрүүл мэндийн газар болон Үндэсний аудитын газар

Нэмэлт мэдээлэл, мэдээллийн эх сурвалж:

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор Б.Болортуул
Утас: 7058-4203, Цахим хаяг: bolortuulb@audit.gov.mn

Аудитын менежер И.Сэмжидмаа Утас: 7058-4207,
Цахим хаяг: semjidmaai@audit.gov.mn

Ахлах аудитор Б.Батжаргал Утас: 7058-4207,
Цахим хаяг: batjargalb@audit.gov.mn

Аудитор М.Ухаанбилэг, М.Ганбилэг Утас: 7058-4207,
Цахим хаяг: ukhaanbilegm@audit.gov.mn ganbilegm@audit.gov.mn

Чойбалсан хот 2023 он

Аудитын зорилго, зорилтууд, хамарсан хүрээ: “Эрүүл мэндийн даатгал, үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоо, үр нөлөө” сэдвээр гүйцэтгэлийн аудит хийж, дүгнэлт гарган зөвлөмж боловсруулан дүнг Үндэсний аудитын газарт болон холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэнэ. Уг зорилтыг хангахын тулд дараах чиглэлээр аудитыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Эрүүл мэндийн даатгалын тогтолцоо, үйл ажиллагааны үр дүн, төрөөс баримтлах бодлогын баримт бичгийн хэрэгжилт хангагдсан эсэх;
2. Эрүүл мэндийн байгууллагаас даатгуулагчийн эрэлт, хэрэгцээ, шаардлагад нийцсэн эрүүл мэндийн чанартай тусламж, үйлчилгээ үзүүлсэн эсэх;

Аудитад Эрүүл мэндийн газар, Эрүүл мэндийн даатгалын хэлтэс, эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч төрийн болон хувийн хэвшлийн байгууллагууд, сумын Эрүүл мэндийн төвүүд, Нийгмийн даатгалын хэлтсийн 2021-2022 оны үйл ажиллагааг хамруулсан.

Аудитын гол үр дүн: ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН ТОГТОЛЦООНД ШИЛЖСЭН 4 ДААТГУУЛАГЧ ИРГЭН ӨӨРТ ОЙР, ӨӨРИЙН СОНГОСОН ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ДААТГАЛААРАА ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ АВЧ ЧАДАХГҮЙ БАЙНА.

- **А. ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДЭД ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ТАЛААР ТУСГАСАН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭ НЬ ХАРИЛЦАН УЯЛДАА ХОЛБООТОЙ БАЙНА.**

А.1 МОНГОЛ УЛСЫН ХӨГЖЛИЙН БОДЛОГЫН УРТ, ДУНД БОЛОН БОГИНО ХУГАЦААНЫ БАРИМТ БИЧИГТ ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ЧАНАР, ХҮРТЭЭМЖТЭЙ ТОГТОЛЦООГ ХӨГЖҮҮЛЭХ ЧИГЛЭЛЭЭР ДЭВШҮҮЛСЭН АРГА ХЭМЖЭЭГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АЖЛЫГ ЗОХИОН БАЙГУУЛСАН БАЙНА.

А.1.1 Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилт, арга хэмжээ нь харилцан уялдаа холбоотой байна.

А.1.3 Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн байгууллагын санхүүжилт өсөж, даатгуулагчдад үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.

- **Б. ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН ҮР ДҮНД СУУРИЛСАН ТОГТОЛЦООНД ШИЛЖСЭН 4 ДААТГУУЛАГЧ ИРГЭН ӨӨРТ ОЙР, ӨӨРИЙН СОНГОСОН ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ДААТГАЛААРАА ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ АВЧ ЧАДАХГҮЙ БАЙНА.**

Б.1 ДОРНОД АЙМГИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГЫН ТӨЛӨВЛӨГӨӨГ ҮНДЭСЛЭЛГҮЙ БАТАЛСАН БАЙНА.

Б.1.1 Дорнод аймгийн Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй баталснаас 41.1 хувиар тасарсан байна.

Б.1.2 Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь нэхэмжлэлийн хяналтыг журмын дагуу хийсэн ч чанар, төлбөрийн хяналтын үр дүнд дүн шинжилгээ хийж тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад өгч ажиллаагүй байна.

Б.1.3 Аймгийн эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь батлагдсан орон тоогоороо ажиллаагүйгээс шалтгаалан эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд газар дээрх хяналт хийх нөхцөл бүрэн бүрдээгүй байна.

Б.1.4 Эрүүл мэндийн даатгалын байгууллагаас эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх эрүүл мэндийн байгууллагын сонгон шалгаруулалтыг ЭМДЕГ-аас зохион байгуулсан байна.

Б.1.5 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай байгуулсан 2022 оны даатгалын гэрээний гүйцэтгэлийг Эрүүл мэндийн даатгалын байгууллага дүгнээгүй байна.

Б.1.6 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад санхүүжилтийг үр нөлөөтэй байхаар тооцож олгохгүй байна.

Б.2 ДААТГУУЛАГЧ ИРГЭН ӨӨРТ ОЙР, ӨӨРИЙН СОНГОСОН ХУВИЙН ХЭВШЛИЙН ЭРҮҮЛ МЭНДИЙН БАЙГУУЛЛАГААС ДААТГАЛААРАА ТУСЛАМЖ, ҮЙЛЧИЛГЭЭ АВЧ ЧАДАХГҮЙ БАЙНА.

Б.2.1 Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч хувийн эмнэлгүүдийг гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд хамруулж, хүртээмжийг нэмэгдүүлээгүй байна.

Б.2.2 Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд даатгуулагч, эмнэлэг, эмийн сан, даатгалын байгууллага болон бусад төрийн байгууллагыг холбосон цахим мэдээллийн системийн хөгжүүлэлт хангалтгүй байна.

Б.2.3 Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь эрүүл мэндийн тусламж үйлчилгээний талаар даатгуулагчийн ирүүлсэн өргөдөл гомдлыг шийдвэрлэж ажилласан байна.

Б.3 ЭРҮҮЛ МЭНДИЙН ДААТГАЛЫН БАЙГУУЛЛАГЫН ДОТООД АУДИТЫН ҮЙЛ АЖИЛЛАГАА ҮР НӨЛӨӨГҮЙ БАЙНА.

Б.3.1 Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хяналт, шинжилгээ үнэлгээний журмыг боловсруулж батлаагүй, Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан "Эрүүл мэндийн салбарын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг мөрдөж ажилладаг байна.

Б.3.2 Эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанарыг бодитойгоор үнэлэх нөхцөл бүрдээгүй байна.

Б.3.3 ЭМДЕГ-ын Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газар нь хяналт тавих чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Дүгнэлт: Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг хийж байна. Үүнд:

1. Хөгжлийн бодлогын баримт бичгүүдэд эрүүл мэндийн даатгалын талаар тусгасан зорилт, арга хэмжээ нь харилцан уялдаа холбоотой байна.
2. Эрүүл мэндийн даатгалын үр дүнд суурилсан санхүүжилтийн тогтолцоонд шилжсэнээр эрүүл мэндийн байгууллагын санхүүжилт өсөж, даатгуулагчдад үзүүлэх тусламж үйлчилгээний хүртээмж нэмэгдсэн байна.
3. Эрүүл мэндийн даатгалын сангийн орлогын төлөвлөгөөг үндэслэлгүй баталснаас орлогын төлөвлөгөө 41.1 хувиар тасарсан байна.
4. Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь нэхэмжлэлийн хяналтыг журмын дагуу хийсэн ч чанар, төлбөрийн хяналтын үр дүнд дүн шинжилгээ хийж тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад өгч ажиллаагүй байна.
5. Хүн ам цөөтэй, өвчлөл бага сумын Эрүүл мэндийн төвд нэг иргэнээр болон тохиолдолд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилт олгох арга нь оновчгүй байна.
6. Аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэс нь батлагдсан орон тоогоороо ажиллаагүйгээс шалтгаалан эрүүл мэндийн байгууллагуудын үйл ажиллагаанд газар дээрх хяналт хийгдэхгүй байна.
7. Эрүүл мэндийн даатгалын байгууллага эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагатай байгуулсан даатгалын гэрээний 2022 оны гүйцэтгэлийг дүгнээгүй байна.
8. Эрүүл мэндийн тусламж үйлчилгээ үзүүлж буй төрийн болон хувийн хэвшлийн эрүүл мэндийн байгууллагуудад санхүүжилтийг үр нөлөөтэй байхаар тооцож олгохгүй байна.
9. Лавлагаа шатлалын эмнэлэгт тохиолдолд суурилсан оношны хамааралтай бүлгээр тооцон олгодог суурь тарифт тогтмол зардлыг оруулан тооцож байгаа нь оновчгүй байна.
10. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч хувийн эмнэлгүүдийг гүйцэтгэлийн санхүүжилтийн тогтолцоонд хамруулж хүртээмжийг нэмэгдүүлэх эрх зүйн орчин бүрдээгүй байна.
11. Эрүүл мэндийн даатгалын үйлчилгээнд даатгуулагч, эмнэлэг, эмийн сан, даатгалын байгууллага болон бусад төрийн байгууллагыг холбосон цахим мэдээллийн системийн хөгжүүлэлт бүрэн хийгдээгүй байна.
12. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хяналт, шинжилгээ үнэлгээний журмыг боловсруулж батлаагүй, Эрүүл мэндийн сайдын тушаалаар баталсан "Эрүүл мэндийн

салбарын үйл ажиллагаанд хяналт, шинжилгээ үнэлгээ хийх нийтлэг журам"-ыг мөрдөж ажилладаг байна.

13. Эрүүл мэндийн даатгалын байгууллагад эрүүл мэндийн тусламж, үйлчилгээний чанарыг бодитоор үнэлэх шалгуур үзүүлэлт хангалтгүй байна.

14. ЭМДЕГ-ын Дотоод аудит, хяналт шинжилгээ, үнэлгээний газар нь хууль тогтоомж, журамд заасан хяналт тавих чиг үүргээ хангалтгүй хэрэгжүүлсэн байна.

Аудитаар нийт 5,441.2 сая төгрөгийн алдаа, зөрчилтэй асуудал илэрсэнд холбогдох байгууллага албан тушаалтан албан шаардлага 1, зөвлөмж 4-ийг өгч, нэгдсэн тайланд тусгуулах 14 саналыг боловсруулсан.

САНАЛ: ҮАГ-ын нэгдсэн тайланд тусгуулах санал.

Эрүүл мэндийн яаманд:

1. Шинээр нэвтрүүлж буй цахим программын сургалтыг орон нутагт зохион байгуулах.
2. Программ, цахим системд холбогдох өөрчлөлтийг хийж, нэгдсэн мэдээллийн сан бий болгох.

Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлд:

1. Эм, эмнэлгийн хэрэгслийн үнэд судалгаа хийж, үнийн өсөлттэй уялдуулан суурь тарифыг өөрчлөх.
2. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэх байгууллагыг сонгон шалгаруулах журамд иргэд өөрт ойр, өөрийн сонгосон эрүүл мэндийн байгууллагаас эмчилгээ үйлчилгээг авах боломжийг нэмэгдүүлж, хувийн эмнэлгийн хамрагдалтыг өсгөх, улсын эмнэлгийн ачааллыг бууруулахаар тооцож шинэчлэх.
3. Сумын эрүүл мэндийн төвд нэг иргэнээр болон тохиолдолд суурилсан гүйцэтгэлийн санхүүжилтийн аргыг бодит байдалд нийцүүлж оновчтой болгох.

Эрүүл мэндийн даатгалын ерөнхий газарт:

1. ЭМДС-гийн орлогыг төлөвлөхдөө орон нутгийн ЭМД-ийн хэлтэс, НД хэлтсээс санал авч байх, мөн цалин хөлсний нэмэгдэл, хөдөлмөрийн хөлсний доод хэмжээний нэмэгдэлтэй уялдуулан тооцож байх.
2. Гүйцэтгэлийн шалгуур үзүүлэлтийг анхан болон лавлагаа шатлалын эмнэлгийн нөхцөлд тохируулж өөрчлөх.
3. Эмчийн гүйцэтгэлийг хянадаг чанар, төлбөрийн мэргэжилтний цалинг хийж буй ажил, эрэмбэ, ач холбогдлыг нь харгалзан тооцож, тогтоох.
4. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудтай байгуулсан гэрээг хугацаанд нь дүгнэж байх.

5. Эмнэлгүүдэд олгож буй урьдчилгаа санхүүжилтийн хувийг бодитой тооцож тогтоох.
6. Эрүүл мэндийн даатгалын байгууллагын хяналт, шинжилгээ-үнэлгээний журам боловсруулж батлах.
7. Гүйцэтгэлийг бодитоор шалгах, чанарыг үнэлэх чанарын шалгуур үзүүлэлт боловсруулж батлуулах.

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яаманд:

1. Өрхийн амьжиргааны түвшин тодорхойлох судалгааг 2016 оноос хойш аваагүй, мэдээллийн санг шинэчлээгүйтэй холбоотойгоор зөрчилтэй асуудал үүсэж байгаа тул амьжиргааны түвшинг тооцох судалгааг авч өрхийн мэдээллийн нэгдсэн санг шинэчлэх.

Нийгмийн даатгалын ерөнхий газарт:

1. ЭМД-ын шимтгэлийг нь төр хариуцан төлж буй амьжиргааны түвшнээс доогуур орлоготой иргэнийг ажил хөдөлмөрт шилжсэн тохиолдолд НДЕГ-ын сангийн программд төрөөс хариуцан төлж буй шимтгэлийг зогсоох өөрчлөлт оруулах.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг холбогдох албан тушаалтнуудад зөвлөж байна. Үүнд:

Аймгийн Эрүүл мэндийн газрын даргад:

1. ЭМДҮЗ-ийн тогтоолоор батлагдсан “жагсаалт, төлбөрийн хэмжээ, төлбөрийн арга, журам”-ыг хэрэгжүүлэхэд эрүүл мэндийн байгууллагыг мэргэжил арга зүйн удирдлагаар хангах арга хэмжээг зохион байгуулж ажиллах.

Дорнод аймгийн Эрүүл мэндийн даатгалын хэлтэст:

1. Чанар, төлбөрийн хяналтын үр дүнд дүн шинжилгээ хийж тусламж, үйлчилгээний чанарыг сайжруулахад чиглэсэн зөвлөмжийг эрүүл мэндийн байгууллагуудад өгч байх.
2. Дорнод аймгийн хэмжээнд эрүүл мэндийн даатгалд хамрагдаагүй малчин, оюутан, суралцагч, тодорхой хөдөлмөр эрхлээгүй иргэдийг даатгалд хамруулах ажлыг үр дүнтэй зохион байгуулах.
3. Эрүүл мэндийн тусламж, үйлчилгээ үзүүлэгч байгууллагуудад “Чанар, төлбөрийн хяналтын журам”-ыг хэрэгжүүлэхтэй холбоотой сургалт зохион байгуулах.

Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллаж, биелэлтийг 2024 оны 11 дүгээр сарын 25-ны дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.